



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 11 дугаар сарын 13

Дугаар 03/09

Баян-Өндөр сум


Хороодын даргыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны даргаар Д.Мөнхболд, Нийгмийн хөгжлийн хорооны даргаар Б.Мөнхзаяа, Эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийн хорооны даргаар С.Ганцогт, Төсөв, санхүүгийн хөгжлийн хорооны даргаар Г.Эрдэнэбат, Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны даргаар О.Мөнх-Од, Дэд бүтэц, хот байгуулалт, гэр хорооллын хөгжлийн хорооны даргаар Д.Гантөмөр, Цахим бодлогын хөгжлийн хорооны даргаар Д.Ганболд, Ёс зүйн хорооны даргаар Б.Мягмарсүрэн нарыг тус тус баталсугай.

2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйл, Хурлын хорооны үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг тус тус ханган ажиллахыг Хурлын хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ